АРХАНГАЙ АЙМГИЙН
СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

АРХАНГАЙ АЙМГИЙН ЭДИЙН ЗАСАГ НИЙГМИЙН БАЙДЛЫН ТУХАЙ ТАНИЛЦУУЛГА

2020/08

www.nso.mn www.arkhangai.nso.mn www.1212.mn

ЭРҮҮЛ МЭНД

Эмнэлгийн байгууллагууд 551 ор, амбулаторийн 99 их эмчтэйгээр хүн амд үйлчилж давхардсан тоогоор 220.0 мянган хүнд амбулаторийн үзлэг хийсний 77.0 мянгад нь урьдчилан сэргийлэх үзлэг хийж 13.3 мянган хүнийг эмнэлэгт хэвтүүлэн эмчилж гаргасан байна.

Вакцинжуулалтанд хамрагдвал зохих 0-2 насны хүүхдийн 98.1 хувийг бүрэн хамруулсны дотор Чулуут, Эрдэнэмандал, Жаргалант, Хайрхан, Хашаат, Хотонт, Цахир сумд 100.0 хувь хамруулсан байна.



Оны эхний 8 сард 1107 эх төрж, 1114 хүүхэд амьд төрсөн нь өнгөрсөн оны мөн үеийнхээс 1.4 хувиар буюу 16 хүүхдээр бага байна.

Хүн амын нас баралт 311 гарсан нь өнгөрсөн оны мөн үеийнхээс 64 тохиолдлоор буюу 17.0 хувиар буурсан байна. Мянган хүнд ноогдох төрөлт 11.7, нас баралт 3.3 ноогдож хүн амын ердийн цэвэр өсөлт 8.4 промил байна.

Төрөхийн улмаас эндсэн эхийн эндэгдэл гараагүй бол 1-5 насны хүүхдийн эндэгдэл 7, нялхсын буюу 0-1 насны хүүхдийн нас баралт 16 гарч мянган амьд төрөлтөд 14.0 ногдож байна.



Аймгийн дүнгээр арван мянган хүн тутмаас 19 нь буюу 242 хүн халдварт өвчнөөр өвчилсөн бөгөөд Өлзийт (35) Булган (33), Эрдэнэбулган (28), Төвшрүүлэх (27), Цахир (25), Жаргалант(25), Батцэнгэл(22), Өндөр-Улаан(21), Ихтамир(20) сумдад аймгийн дунджаас дээгүүр бусад сумдад аймгийн дунджаас доогуур байна. Халдварт өвчнөөр өвчлөгсдийн 5.8 хувь нь салхин цэцгээр, 32.6 хувь нь цусан суулгаар, 34.7 хувь нь бэлгийн замын халдварт өвчнөөр, 17.4 хувь нь сүрьеэгээр, 9.5 хувь нь бусад халдварт өвчнөөр өвчилсөн байна. Халдварт өвчний гаралт өнгөрсөн оны мөн үеийнхээс 34.0 хувиар буюу 125 тохиолдлоор буурсан байна.

АЖИЛГҮЙДЭЛ, АЖЛЫН БАЙР

9 дүгээр сарын 1-ний байдлаар хөдөлмөр эрхлэлтийн албанд бүртгэлтэй ажил идэвхтэй хайж байгаа 927 ажилгүй хүн байгаагийн 52.3 хувь нь буюу 485 нь эмэгтэйчүүд байна. Хөдөлмөрийн насны 10.0 мянган хүн тутамд 143 ажилгүйчүүд ноогдож байгаа бөгөөд өнгөрсөн оны мөн үеийнхээс бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо 4.7 хувиар буурсан байна. Бүртгэлтэй ажилгүйчүүдийн 99.2 хувь нь боловсролтой иргэд байгаагийн 133 нь дээд, 36 нь тусгай дунд болон мэргэжлийн анхан шатны, 734 нь бүрэн болон бүрэн бус дунд, 17 нь бага боловсролтой хүмүүс байна. 8 дугаар сард ажилгүйчүүдийн бүртгэлд 102 хүн шинээр бүртгүүлж, 121 хүн ажил идэвхитэй хайхаа больсноос идэвхигүй болж 34 хүн ажилд зуучлуулан орсон байна**.**

Оны эхний 8 сард аймгийн дүнгээр 620 ажлын байр шинээр бий болгосон байна. Шинэ ажлын байрыг сумдаар үзвэл Эрдэнэбулган сум 139, Эрдэнэмандал, Өндөрулаан, Хашаат, Хангай, Хотонт, Тариат, Цэнхэр сумд 32 - 63 ажлын байрыг, Булган, Өлзийт, Чулуут, Хайрхан, Ихтамир, Өгийнуур, Төвшрүүлэх, Батцэнгэл, Цахир сумд 7 - 28 ажлын байрыг бий болгожээ.

НИЙГМИЙН ДААТГАЛ ХАЛАМЖ

Нийгмийн даатгалын сангийн орлого оны эхний 8 сард 48.5 тэрбум төг, зарлага 45.3 тэрбум төг болж өмнөх оныхоос орлого 9186.4 сая төг буюу 23.4 хувиар, зарлага 7287.4 сая төг буюу 19.2 хувиар өслөө.

Нийгмийн даатгалын сангийн орлого өмнөх оныхоос 9186.4 сая төгрөгөөр өсөхөд тэтгэврийн даатгалын сангийн орлого 24.5 хувиар, тэтгэмжийн даатгалын сангийн орлого 20.2 хувиар, эрүүл мэндийн даатгалын сангийн орлого 5.7 хувиар, ҮОМШӨ*-ний даатгалын сангийн орлого 1.3 хувиар тус тус өссөн байна.

Нийгмийн даатгалын сангийн зарлага өмнөх оныхоос 19.2 хувиар өсөхөд тэтгэврийн даатгалын сангийн зарлага 20.1 хувиар, тэтгэмжийн даатгалын сангийн зарлага 17.4 хувиар, эрүүл мэндийн даатгалын сангийн зарлага 7.4 хувиар, ажилгүйдлийн даатгалын сангийн зарлага 64.5 хувиар өссөн нь шууд нөлөөлөв. Тэтгэврийн даатгалын сангаас тэтгэвэрт 14.5 мянган хүнд 41.2 тэрбум төгрөг, тэтгэмжийн даатгалын сангаас бүх төрлийн тэтгэмжид 1631 хүнд 1542.8 сая төгрөгийг олгосон байна.

Нийгмийн халамжийн сангаас олгосон мөнгөний 60.3 хувийг халамжийн тэтгэврээр, 32.0 хувийг нөхцөлт мөнгөн тэтгэмжээр, 7.7 хувийг ахмад настан хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд олгосон болон хүнс тэжээлийн хөнгөлөлт тусламжид зарцуулж байна.

Оны эхний 8 сард нийгмийн халамжийн сан болон хүний хөгжил сангаас давхардсан тоогоор 52.1 мянган хүнд 10.0 тэрбум төгрөгийн тэтгэмж хөнгөлөлт тусламж, хишиг олгосон байна. Нийгмийн халамж үйлчилгээгээр олгосон нийт мөнгөний 66.3 хувь нь нийгмийн халамжийн сангаас олгосон халамжийн тэтгэвэр, нөхцөлт мөнгөн тэтгэмж, хөнгөлөлт, 33.7 хувийг улсын төсвөөс олгосон тэтгэмж тусламж эзэлж байна.

ГЭМТ ХЭРЭГ

Аймгийн хэмжээгээр 196 хүн гэмт хэрэгт холбогдож 332 гэмт хэрэг гарсны дотор хүний амь бие эрүүл мэндийн эсрэг хэрэг 86, өмчлөх эрхийн эсрэг 186, тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг 19, байгаль хамгаалах журмын эсрэг 22, бусад 19 хэрэг гарсан байна.



Гэмт хэргийн улмаас 12 хүн нас барж, 101 хүн гэмтэж бэртэн улс болон иргэдэд 1230.9 сая төгрөгийн хохирол учирсан байна. Бүртгэгдсэн нийт хэргийн 7.5 хувийг бүлэглэж 17.5 хувийг согтуугаар үйлдсэн байгаа ба зөрчил гаргасан 58 хүнийг албадан саатуулж 260 хүнийг баривчилсан байна.



Өнгөрсөн оны мөн үетэй зэрэгцүүлэхэд бүртгэгдсэн гэмт хэргийн тоо 16.6 хувиар буюу 66 тохиолдлоор буурсаны дотор тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг 36.7 хувиар буюу 11 тохиолдлоор, өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг 16.6 хувиар буюу 37 тохиолдлоор буурсан бол байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэрэг 17 тохиолдлоор буюу 4 дахин өссөн байна.

ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ОРЛОГО

Улсын төвлөрсөн төсвийн шилжүүлэг дэмжлэгийг оруулан тооцсоноор 2020 оны эхний 8 сард аймгийн төсөвт 114612.8 сая төгрөгийн орлого төвлөрүүлэхээс 16594.4 сая төгрөгийн орлого оруулж төлөвлөгөөг 126.3 хувиар биелүүлсэн байна.

Улсын төсвийн шилжүүлэг дэмжлэгийг оруулахгүйгээр аймаг өөрөө 4601.8 сая төгрөгийн орлого бүрдүүлэхээс 6583.4 сая төгрөгийн орлогыг төвлөрүүлэн төлөвлөгөөг 116.7 хувиар биелүүллээ. Төсвийн орлогын төлөвлөгөөг бүх сумд 117.3 хувиас 299.6 хувиар давуулан биелүүлсэн байна.

Орон нутгийн төсвийн орлогын бүтэц, хувиар



Аймгийн төсвийн орлогын 60.3 хувийг тусламжийн орлогоор, 26.9 хувийг орлогын албан татвараар, 3.1 хувийг

өмчийн татвараар, 3.4 хувийг бусад албан татвараар, 5.9 хувийг татварын бус орлогоор, 0.4 хувийг хөрөнгийн орлогоор бүрдүүлж байна.

Орлогыг нэр төрлөөр нь үзвэл рашаан ус ашигласны төлбөр, газрын төлбөр, бууны татвар, газрын дуудлага худалдааны орлогоос бусад нэрийн орлогуудыг 101.2 хувиас 2.2 дахин биелүүлсэн байна.

Улсын төвлөрсөн төсөвт аж ахуй нэгжийн орлогын татвараар 204.0 сая төгрөг, нэмэгдсэн өртгийн албан татвараар 661.0 сая төгрөг, агаарын бохирдлын төлбөрөөр 30.9 сая төгрөг, ус бохирдуулсны төлбөр 5.2 сая төгрөг бүгд 901.2 сая төгрөгийг шилжүүлж даалгаврыг 20.2 хувиар давуулан биелүүллээ.

МӨНГӨ ЗЭЭЛ, ХАДГАЛАМЖ

Манай аймагт арилжааны 5 банкны салбар иргэд аж ахуй нэгж байгууллагуудад үйлчилгээ үзүүлж байна. Монгол банкны мэдээгээр арилжааны банкууд монгол банкнаас зузаатгалаар 15.7 тэрбум төгрөгийг авч 19.3 тэрбум төгрөгийг гүйлгээнээс эргүүлэн татсан байна.

Оны эхний 8 сард банкууд 41.3 мянган иргэд, аж ахуй нэгжид 115.7 тэрбум төгрөгийн зээл олгосон байна.



Өнгөрсөн оны мөн үеийнхтэй зэрэгцүүлэхэд иргэдийн хадгаламжийн үлдэгдэл 18.9 хувиар, олгосон зээлийн хэмжээ 39.7 хувиар тус тус өссөн бол анхаарал хандуулах зээлийн хэмжээ 32.7 хувиар буурсан байна. Харин чанаргүй зээлийн хэмжээ 46.2 хувиар нэмэгдсэн байна.

ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНЭ

Энэ оны 8 дугаар сард бараа үйлчилгээний үнэ тариф өмнөх сарынхаас 1.6 хувиар буурч, харин өнгөрсөн оны мөн үеийнхээс 1.5 хувиар өссөн байна.

Өнгөрсөн 7 дугаар сартай зэрэгцүүлэхэд хэрэглээний сагсанд авсан 238 нэрийн бараа үйлчилгээний үнэ тарифын 10.9 хувь буюу 26 нэр төрлийн бүтээгдэхүүний үнэ өсч, 7.1

хувь буюу 17 нэр төрлийн бүтээгдэхүүний үнэ буурч 82.0 хувийнх нь үнэ тогтвортой байлаа. Тухайлбал өмнөх сарынхаас адуу, хонь, үхэрийн мах, өндөг, манжин, төмс, лууван, хорхой ааруулны үнэ 0.4-59.9 хувиар буурч харин бүх төрлийн бензин шатахуун, гурил, гоймон, шар будаа, пиво, тосон будаг, шоколад, жинсэн өмд зэргийн үнэ 0.1-10.0 хувиар өссөн байна.

Харин өмнөх оны мөн үетэй зэрэгцүүлэхэд 11.8 хувийнх нь буюу 28 нэрийн бараа үйлчилгээний үнэ буурч, 41.1 хувийнх нь буюу 98 нэрийн бараа үйлчилгээний үнэ тариф өсч, 47.1 хувийнх нь үнэ тогтвортой байна.

Өнгөрсөн оны мөн үеийнхээс үхрийн мах, бүх төрлийн бензин шатахуун, дотор мах, байцай, тараг, mp3, LCD телевизор, сурагч дэвтэр, эдийн саван зэргийн үнэ 0.4 – 33.3 хувиар буурч харин тахиа, хонь, адууны мах, төмс, лууван, манжин, цемент, тосон будаг, янжуур тамхи, гурил, задгай масло, давс, өөхөн тос, лаа зэрэг барааны үнэ 0.3 – 73.1 хувиар нэмэгдсэн байна.

ХӨДӨӨ АЖ АХУЙ

7 дугаар сарын 1-ний байдлаар оны эхний хээлтэгч малын 73.4 хувь нь буюу 1946.4 мянган эх мал төллөж гарсан төлийн 84.7 хувь нь буюу 1647.7 мянган төл бойжиж байна.

Төл бойжилтыг малын төрлөөр үзвэл гарсан ботгоны 96.8 хувь, унаганы 89.9 хувь, тугалын 93.0 хувь хурганы 85.2 хувь, ишигний 79.0 хувь нь бойжиж байна.

Сумдаас Өгийнуур, Төвшрүүлэх, Батцэнгэл, Булган, Чулуут сумд гарсан төлөө 99.2 – 95.5 хувиар бойжуулж байна.



Өнгөрсөн оны мөн үеийнхээс аймгийн дүнгээр төлөсөн эх мал 2.7 хувиар, бойжиж байгаа төлийн тоо 15.2 хувиар бага байгаа бол төлийн хорогдол 5.3 дахин их байна.

Эхний 6 сарын байдлаар оны эхний мал 94.5 хувиар онд орж оны эхний малын 5.5 хувь буюу 341.8 мянган том мал хорогдов. Хорогдсон малын 0.01 хувийг тэмээ, 5.7 хувийг адуу, 7.1 хувийг үхэр, 54.8 хувийг хонь, 32.4 хувийг ямааны хорогдол эзэлж байна.

Сумдаас Хайрхан, Өлзийт, Жаргалант, Цэцэрлэг сумдын оны эхний малын 10.6 – 11.8 хувь нь, Эрдэнэбулган, Батцэнгэл, Өгийнуур, Төвшрүүлэх сумдын оны эхний малын 1.0-1.5 хувь нь хорогдсон байна.

Энэ хавар 8319 га-д үр тариа, 251.5 га-д төмс, 128.1 га-д хүнсний ногоо, 2945.79 га-д малын тэжээлийн ургамал, 901 га-д техникийн ургамал тус тус тариалаад байна.

Өнгөрсөн оны энэ үеийнхтэй зэрэгцүүлэхэд үр тариа 8.0 хувиар, төмс 4.8 хувиар буурч харин хүнсний ногоо 1.6 хувиар, техникийн ургамал 38.6 хувиар, тэжээлийн ургамал 2.7 дахин их тариалсан байна.

2020 онд манай аймаг ойгоос 93.6 мянган м3 галын түлээ, 10.6 мянган м3 хэрэгцээний мод, бүгд 104.2 мянган м3

мод авч ашиглахаар баталсанаас оны эхний 8 сард 31.4 мянган м3 галын түлээ, 7.4 мянган м3 хэрэгцээний мод, бүгд 38.8 мянган м3 мод бэлтгэж хэрэглэсэн байна. Бэлтгэсэн модны гоожингийн орлогоор 131.0 сая төгрөг төсвийн орлогод оруулсан байна.

АЖ ҮЙЛДВЭР

Үйлдвэрийн газрууд эхний 8 сард оны үнээр 4182.8 сая төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж 3925.9 сая төгрөгийн бүтээгдэхүүн борлуулсан нь өнгөрсөн оныхоос 13.5 - 6.6 хувиар их байна. Зэрэгцүүлэх үнээр үнэлснээр 2402.1 сая төгрөгийн нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн нь өнгөрсөн оны мөн үеийнхээс 1.6 хувиар их байна.

Нийт үйлдвэрлэлтийн 24.5 хувийг хүнс ундааны, 1.3 хувийг хэвлэлийн, 48.7 хувийг дулааны эрчим хүчний, 12.8 хувийг усан хангамж, 2.9 хувийг модон эдлэлийн, 8.0 хувийг гутал хувцасны, 1.8 хувийг барилгын үйлдвэрлэл болон бусад үйлдвэрлэл эзэлж байна.

Гол нэрийн бүтээгдэхүүнээс талх нарийн боов, хэрчсэн гурил, бууз, борц, эмээл болон гэрийн мод, монгол дээл, монгол гуталын үйлдвэрлэл 0.5 – 92.7 хувиар нэмэгдлээ. Харин савласан цэвэр ус, хүснэгт, дулаан, эсгий

шаахай, зүсмэл, түгээсэн цэвэр ус, савхин гутал, гэрийн модны үйлдвэрлэл 0.5 – 28.8 хувиар буурсан байна.



Тээврийн байгууллагууд 36.1 мянган зорчигч, 27.6 мянган тонн ачаа тээвэрлэн 15.1 сая хүн км, 3.1 сая тнкм ажил гүйцэтгэн 777.5 сая төгрөгийн орлоготой ажиллаа. Өнгөрсөн оны мөн үеийнхээс зорчигч, зорчигч эргэлт, ачаа, эргэлтийн хэмжээ 7.7-20.3 хувиар буурсан байна. Харин орлогын хэмжээ 47.3 хувиар өссөн байна.

Холбооны салбарын нийт орлого эхний 8 сард 5.8 тэрбум төгрөгийн орлоготой ажиллаж давхардсан тоогоор 67.0 мянган хүнд интернэтийн үйлчилгээ, 21.8 мянган кабелийн телевизийн хэрэглэгчтэй болсныг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулвал орлого 1.7 хувиар буурч, кабелийн телевиз хэрэглэгчийн тоо 14.4 хувиар өссөн байна.

ЦАГ УУРЫН БАЙДАЛ

8 дугаар сард агаарын дундаж температур 11.1-ээс 17.8 хэм байсан бөгөөд хамгийн их дулаан Батцэнгэл, Хашаат, Хотонт, Өлзийт, Өгийнуур, Хайрхан, Эрдэнэмандал сумдад 26-28.0 хэм хүрч байсан бол хамгийн хүйтэн нь Чулуут, Хангай, Өндөр-Улаан, Цэцэрлэг, Булган, Цахир сумдад 2.0-оос 0.0 хэмд хүрч хүйтэрч байсан байна.

Цэцэрлэг , Жаргалант, Эрдэнэбулган сумдын нутгаар 110.7 – 137.4 мм хур тундас орсон нь хамгийн өндөр байгаа Цахир, Хотонт, Хангай, Тариат сумдад 44.7 – 67.6 мм хур тундас орсон нь хамгийн бага байна.

.

Статистикийн хэлтэс
2020.09.10